

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙН ГЭР ХОРООЛЛЫН
ӨРХӨД ЦАХИЛГААН ХАЛААГУУР БОЛОН БҮХ ТӨРЛИЙН ХИЙН ТҮЛШЭЭР
АЖИЛЛАДАГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ, ТЭДГЭЭРИЙН
ХЭРЭГЛЭЭНД ҮНИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ногоон бүсийн гэр хорооллын өрхөд эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур (Цаашид цахилгаан халаагуур гэх) болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал (“Цаашид урамшуулал” гэх) олгохтой холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журам нь Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах Ногоон бүсийн өрхөд хамаарна.

**Хоёр.Урамшууллын хэлбэр, хувь хэмжээ,
хамрах хүрээ, хугацаа**

2.1.Энэ журамд заасан урамшуулалд ногоон бүсийн гэр хорооллын хийн түлшнээс бусад түлшээр ажилладаг зуух ашиглахаас татгалзаж (цаашид хатуу түлшний хэрэглээнээс татгалзсан гэх), гэр, орон сууцаа дулаалж, дулаан алдагдалгүй болгосон цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулсан өрх хамрагдана.

2.2.Хатуу түлшний хэрэглээнээс татгалзсан энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан өрхөд дараах дэмжлэг, урамшууллыг олгоно:

2.2.1.тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулах;

2.2.2.тухайн оны 09 дүгээр сарын 15-ний өдрөөс эхлэн дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хэрэглээнд 100,000 (нэг зуун мянга) хүртэлх төгрөгийн урамшууллыг олгох:

2.2.3.өрхийн хэрэглээний төлбөр энэ журмын 2.2.2-т заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд тухайн сард хэрэглэсэн хэрэглээгээр нь тооцож олгоно.

Гурав.Урамшуулал тооцох

3.1.Цахилгаан халаагуур хэрэглэгч өрхийн хэрэглээний зардлыг дараах байдлаар тооцож, үнийн урамшуулал олгоно:

3.1.1.цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага нь цахилгаан халаагуур хэрэглэгчийн хэрэглээний зардлаас энэ журмын 2.2.2-т заасан дүнгээр урамшуулал тооцох;

3.1.2.энэ журмын 2.2.2-т заасан хугацаанд өрхийн хэрэглээний урамшууллыг “Тавантолгой түлш” ХХК нь цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагаас ирүүлсэн тайланг үндэслэн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор шилжүүлэх;

3.1.3.цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага нь цахилгааны үнийн урамшуулал үзүүлсэн мэдээ гаргаж, холбогдох газарт тайлагнана.

3.2.Бүх төрлийн хийн түлшний халаагуурын систем хэрэглэгч өрхийн хэрэглээний зардлыг дараах байдлаар тооцож, үнийн урамшуулал олгох үүнд:

3.2.1.бүх төрлийн хийн түлшээр хангагч нийслэлийн асуудал хариуцсан байгууллага нь өрхийн хийн түлшний хэрэглээг тооцохдоо энэ журмын 2.2.2-т заасан дүнгээр урамшуулал тооцох;

3.2.2.энэ журмын 2.2.2-т заасан хугацаанд өрхийн хэрэглээний урамшууллыг нийслэлийн “Тавантолгой түлш” ХХК нь хийн түлшээр хангагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор шилжүүлэх;

3.2.3.хийн түлшээр хангагч байгууллага нь хийн түлшний үнийн урамшуулал үзүүлсэн мэдээ гаргаж, холбогдох газарт тайлагнана.

Дөрөв.Хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1.Хэрэглэгч дараах эрхтэй:

4.1.1.энэ журамд заасны дагуу урамшуулал авах;

4.1.2.энэ журмын 2.2-т заасан урамшуулалд хамрагдах хүсэлтээ харьяа дүүргийн Засаг даргад гаргах;

4.1.3.энэ журмын 2.1-т заасан халаалтын эх үүсвэрийн ашиглалтын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

4.1.4.энэ журамтай холбоотой санал, хүсэлт, гомдол гаргаж болно.

4.2.Хэрэглэгч дараах үүрэгтэй:

4.2.1.гэр орон сууцаа дулаалж, дулаан алдагдалгүй болгож хорооны Засаг даргад бүртгүүлсэн байх;

4.2.2.хатуу түлшний хэрэглээнээс татгалзсан байх;

4.2.3.өмнөх хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний болон бүх төрлийн хийн түлшний өр, төлбөрийг барагдуулах;

4.2.4.өмнөх сарын хэрэглээний төлбөрийн үлдэгдэлгүй тохиолдолд дараа сарын үнийн урамшуулалд хамрагдах;

4.2.5.хэрэглээний төлбөр энэ журмын 2.2.2-т заасан хэмжээнээс давсан тохиолдолд илүү төлбөрийг төлөх;

4.2.6.өрх нь энэ журмын 2.2.1-т заасан халаалтын эх үүсвэрийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хариуцах;

4.2.7.өрх суурилуулсан тоног төхөөрөмжийг бусдад худалдах, дамжуулахгүй байх, бусдад шилжүүлэн эвдэж гэмтээсэн тохиолдолд төлбөрийг тухайн үеийн ханшаар тооцож, барагдуулах;

4.2.8.урамшуулалд хамрагдсан өрх нь суурилуулсан тоног төхөөрөмжийг тогтмол ашиглаагүй, хатуу түлш хэрэглэсэн нь удаа дараагийн шалгалтаар тогтоогдсон тохиолдолд тухайн тоног төхөөрөмж, төхөөрөмжийг суурилуулахад гарсан болон үнийн урамшуулалд олгосон бүх зардлыг 100 хувь буцаан төлнө.

Тав.Төрийн байгууллагын эрх, үүрэг

5.1.Дүүргийн Засаг дарга нь хороо тус бүрд Нийслэлийн Хяналт шалгалт, Агаар, орчны бохирдол, Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага, “Тавантолгой түлш” ХХК, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ, Нийслэлийн цагдаагийн удирдах байгууллагын төлөөллийг оролцуулан Комисс (“цаашид комисс” гэх) байгуулна.

5.2.Комисс нь өрхийг урамшуулалд хамруулахаас өмнө гэр орон сууцаа дулаалж, дулаан алдагдалгүй болгосон эсэх дээр дүгнэлт гаргана.

5.3.Дүүргийн Засаг дарга нь энэ журмын 2.1-т заасан өрхийн хүсэлтийг үндэслэн зөвшилцөх ажлыг зохион байгуулж, урамшуулалд хамрагдах өрхийн судалгааг нэгтгэн “Тавантолгой түлш” ХХК-д хүргүүлнэ.

5.4.Энэ журмын 2.2-т заасан урамшууллыг олгохдоо “Тавантолгой түлш” ХХК-ийн орлогоос санхүүжүүлнэ.

5.5.“Тавантолгой түлш” ХХК нь дүүргийн Засаг дарга нараас ирүүлсэн судалгаанд үндэслэн тухайн оны төсвийн тооцоог гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.

5.6.“Тавантолгой түлш” ХХК, хорооны Засаг дарга нь комиссын дүгнэлтийг үндэслэн энэ журмын 2.2.1-т заасан тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг дүүргийн өмчид бүртгэж, эзэмшил, ашиглалтад хяналт тавих, урамшуулалд хамрагдах нөхцөлийг хангасан өрхтэй гурвалсан гэрээ байгуулна.

5.7.“Тавантолгой түлш” ХХК нь эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшний халаалтын системийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран өрхөд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг суурилуулах ажлыг зохион байгуулна.

Зургаа.Хяналт тавих, хариуцлага

6.1.Хэрэглэгчийн цахилгаан тоноглол, хийн түлшний системийн аюулгүй байдалд Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар хяналт тавина.

6.2.Энэ журмын хэрэгжилтэд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Хяналт шалгалтын газар хяналт тавина.

6.3.Энэ журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

---oOo---